



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЦУОШТөвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2020/105/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2020 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: Цахим хаяг: 70342850

Аудитын менежер:

Ж.Энхцоодол

Утас: Цахим хаяг: 70342716

Ахлах аудитор:

П.Мөнхтуяа

Утас: Цахим хаяг: 70342716

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсонүгийнжагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.13. Шилэн дансны мэдээлэл	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Менежментийн захидал	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	11
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	11
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	12
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	19


**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020-01-28 № 14
танай _____ -ны № _____ Т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу УЦУОШТөвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

УЦУОШТөвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар УЦУОШТөвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

006020041

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ДАНХБАЯР

2.1. Оршил

УЦУОШТ-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн шууд захирагч С.Жаргалсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн нярвын санхүүгийн программ ашиглах, ЗГ-ын 184 дүгээр тогтоолуудыг баримталж ажиллах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудитхийхүндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу УЦУОШТ-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

УЦУОШТ-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 27-ноос 2020 оны 01 дүгээр сарын 28-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор П.Мөнхтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

УЦУОШТ-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 17 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйлчиллага, хууль, эрх зүйн орчин

УЦУОШТ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Булган аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний алба нь Булган аймгийн УЦУОШТөв нь ус цаг уур орчны шинжилгээг чанартай шуурхай хийж аймаг орон нутгийнхаа албан байгууллага ард иргэдэд мэдээллээр үйлчлэх байгалийн гамшигт үзэгдэл, орчны ноцтой бохирдлоос урьдчилан сээрэмжлүүлэх замаар хувь хүн, нийгэмд учрах хохирлыг бууруулахад төр захиргааны байгууллагад үйлчлэх уур амьсгалын нөөцийг бүрэн ашиглуулах нөхцөлийг бүрдүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилго тодорхойлон ажиллажээ.

Үүнд:

- Хөтөлбөрийн дагуу шинжилгээний ажлыг чанартай сайн хийж ажиглалтын чанарыг өмнөх оноос ахиулах
- Мэдээлэл үйлчилгээний ажлын чанарыг өмнөх оноос бууруулахгүй ахицтай ажиллах, хэрэглэгчдэд хүргэх хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- ТАТХ

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

УЦУОШТөв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Accolous, цалингийн Payroll программ гэсэн программ хангамжууд ашигладаг байна.

УЦУОШТ-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар УЦУОШТ-ийн 2019 онд бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 9 эрсдэлтэй асуудалд 7 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг суурь үзүүлэлт болгон авч эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 512388.2 мянган төгрөгөөс тооцон 10247.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг нийт зардлын 2 хувь буюу 20669.9 мянган төгрөгөөр тооцсон нь батлагдсан төсөв гүйцэтгэлийн зардлыг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг үзэхэд холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

УЦУУШТөвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 321833.1 мянган төгрөгөөр буюу 28.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	146632.9	484591.6	337958.7
Үндсэн хөрөнгө	661534.9	645409.3	16125.6
Нийт хөрөнгө	808167.9	1130000.9	321833.1
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	808167.9	1130000.9	321833.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	808167.9	1130000.9	321833.1

Тус газар нь өмнөх оны авлага өглөгийн үлдэгдэлгүй тухайн онд авлага өглөг нэмж үүсээгүй болно.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь төсвийн хөрөнгөөр 28821.0 мянган төгрөгийн материал худалдан авч ЦУОШГ-аас 362630.4 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал шилжүүлэн авч жилийн эцэст 53492.8 мянган төгрөгийн материал зарцуулан ажиллажээ.

Энэ нь төсвийн хөрөнгөөр шаардлагатай материалыг худалдан авч шилжүүлэн өгсөн материал нь цаашид ашиглагдах боломжтой гэж үзэж байна. Бараа материалын 7 төрлийн бараа материалын 484591.6 мянган төгрөгийн нөөц үүсгэн үлдэгдэлтэй байгаагаас 76.6 хувийг эзэлж байгаа нь дээд газраас шилжүүлэн өгсөн материалын үлдэгдэл эзэлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1057370.4 мянган төгрөгийн үлдэгдлийг 560022.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж өссөн нь ЦУОШГ-аас хандив тусламжаар шилжүүлэн өгснийг үндсэн хөрөнгийн тайланд бүртгэж тайлагнасан, 312719.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг цаашид ашиглах боломжгүй болсон тул Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А-1/4062 тоот зөвшөөрөл олгох тухай албан бичгийн дагуу акталж данс бүртгэлээс хасаж тайлагнажээ.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 50912.3 мянган төгрөгийн, ЦУОШГ-аас 5990.3 мянган төгрөгийн хөрөнгийг хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн хөрөнгөө нэмэгдүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн акталж хасагдсан хөрөнгө байхгүй болно.

Биет бус хөрөнгөөс 6733.6 мянган төгрөгийн өртөгтэй программ хангамжийн хуримтлагдсан элэгдлийн үлдэгдэл 6663.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнаж өмнөх оноос 30.0 мянган төгрөгийн элэгдэл бодогдон үлдэх өртөг 69.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Өр төлбөр дансанд шинээр өр төлбөр үүсээгүй өр төлбөргүй тайлагнажээ.

Урт хугацаат өр төлбөр үүсээгүй болно.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 808167.9 мянган төгрөг дээр 321833.1 мянган төгрөгөөр өссөн нь ЦУОШГ болон ОНХО-ын тусламж хандиваар олгосон материал, хөрөнгө нэмж бүртгэснээс шалтгаалжээ. Энэ нь өөрийн байгууллагын хөрөнгө нэмэгдэж байгаа ч шаардлагатай материал хөрөнгөтэй болж байгаа байгууллагын үйл ажиллагаа хэвийн доголдолгүй явагдах болно гэж үзэж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 205.0 мянган төгрөгийн бичилт нь үр дүнгийн тайлангийн зарлагын данс буруу сонгож илэрхийлсэнтэй холбоотой байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар УЦУОШГ-ын санхүүгийн тайлант онд 100.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 100.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 100 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100.0	100.0	0	100
Нийт дүн	100.0	100.0	0	100

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 3 зорилтот хөтөлбөрт зориулан 932697.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 930381.9 мянган төгрөгийг урсгал зардалд, 2315.9 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд тус тус зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 932597.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 100.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан үзэхэд 932597.8 мянган төгрөгийг улсын төсвөөс 3978.0 мянган төгрөгийг аймгийн ЗДН-хөрөнгөөс, 100.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагаанаас нийт 936675.8 мянган төгрөгийн орлогын санхүүжилт авсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан харахад батлагдсан төсвийг хуваарийн дагуу зарцуулж төсвийн хэлбэлзлээр гүйцэтгэлийн тайланг тайлагнажээ. Үүнээс НДШ-ээс цалингийн зардалд 324.4 мянган төгрөгийг шилжүүлсэн цалингийн

зардал хүрэлцэхгүй дутагдсан шалтгаанаас үүссэн байна. Урсгал зардал багаж хэрэглэлийн зардлаас 2135.9 мянган төгрөгийг зарцуулж хөрөнгө бэлтгэжээ.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд төсөв батлагдаагүй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 931859.9 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь тухайн жилд зарцуулах төсвийн төслийг оновчтой төлөвлөж батлуулжээ.

Нэмэлт төсөв: Засаг даргын газрын нөөц сангаас нэмэлт дансаар 3978.0 мянган төгрөгийн нэмэлт дансаар орлого авч орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс шатахууны зардалд 1092.0, шуудан холбооны зардалд 1350.0, томилолтын зардалд 1536.0 мянган төгрөг буюу нийт 3978.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 9 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 9 эрсдэл тодорхойлж нийт 9 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 29026.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 205.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 28821.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 28821.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Няравын санхүүгийн программ ашиглаж бараа материалын орлого, зарлагын зарцуулалтын тайланг няраваар гаргаж хэвших нь зүйтэй гэж үзлээ.

2.13. Шилэн дансны мэдээлэл

УЦУОШГ нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу бүрэн мэдээлж ажилласныг нийцлийн аудитаар авч үзэх болно.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж өгөөгүй болно.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид УЦУОШГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

УЦУОШГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний

удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг табидний хамтынажиллагааны байрсууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Бараа материал

Илрүүлэлт: Бараа материалын орлого, зарлагыг нярвын материалын орлого зарлагатай түүвэрлэн шалгахад нярав бараа материалын орлого зарлагын нэгтгэлийн тайлан гаргадаггүй, санхүүгийн программаас үлдэгдлийн журналыг хэвлэж анхан шатны баримт бүрдүүлж ажилласан.

Няравын санхүүгийн программ ашигладаггүй цаашид нярвын санхүүгийн программ ашиглаж материалын тайланг тайлагнах шаардлагатай байна.

1.1 Эрсдэл

Санхүүгийн үйл ажиллагаа доголдох

1.2 Өгсөн зөвлөмж

НББ-ийн тухай хуулийн 13.1, Сангийн сайдын 47 дугаар тушаалыг мөрдөж ажиллах.

1.3 Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Зөвлөмжийн дагуу ажиллах

2. Үндсэн хөрөнгө

Илрүүлэлт: Тус газрын автомашин ашиглалт, автомашины хөдөлгүүрийн багтаамжийг ЗГ-ын тогтоолын дагуу үзэхэд үндсэн хөрөнгийн тайланд бүртгэлтэй Рајеро маркийн БУА-82-87 дугаартай автомашин нь В-3490 хөдөлгүүрийн багтаамжтай автомашин ашигладаг зөрчил илэрлээ.

2.1 Эрсдэл

Төлөвлөсөн зардал дутагдах, өр, авлага нэмэгдэх.

2.2 Өгсөн зөвлөмж

Засгийн газрын 184 дүгээр тогтоолын дагуу ажиллах.

2.3 Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Зөвлөмжийн дагуу ажиллах

Мэдэгдэл:

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тооцож 2020 оны 05 сарын 15-ны дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг мэдэгдье.

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

УЦУОШТөв

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>146,632,971.31</u>	<u>484,591,642.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	146,632,971.31	484,591,642.00
351	Түүхий эд материал	30,179,897.65	371,221,525.91
35110	Тусгай зориулалттай материал	30,179,897.65	371,221,525.91
354	Хангамжийн материал	114,523,073.66	111,200,116.09
35410	Бичиг хэргийн материал	1,572,320.00	1,691,740.00
35420	Аж ахуйн материал	106,575,653.66	104,870,976.09
35440	Түлш, шатах тослох материал	6,051,800.00	3,722,000.00
35450	Барилгын засварын материал	323,300.00	915,400.00
35600	Мал амьтад	1,930,000.00	2,170,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>661,534,908.02</u>	<u>645,776,792.97</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	661,534,908.02	645,776,792.97
392	Биет хөрөнгө	440,514,908.20	424,786,793.15
39201	Барилга, байгууламж, орон сууц	380,204,318.49	380,716,638.49
39202	Хуримтлагдсан элэгдэл	-4,550,197.20	-20,904,936.64
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,868,000.00	73,868,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-33,668,000.00	-38,534,666.69
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	389,058,513.85	93,228,609.73
39206	Хуримтлагдсан элэгдэл	-330,685,764.32	-69,948,585.52
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,925,202.83	27,889,877.83
39208	Хуримтлагдсан элэгдэл	-19,815,285.45	-21,528,144.05
393	Биет бус хөрөнгө	221,019,999.82	220,989,999.82
39301	программ хангамж	6,733,657.00	6,733,657.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-6,633,657.18	-6,663,657.18
39303	Бусад биет бус хөрөнгө	220,920,000.00	220,920,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>808,167,879.33</u>	<u>1,130,368,434.97</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>808,167,879.33</u>	<u>1,130,368,434.97</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	808,167,879.33	1,130,368,434.97
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	562,110,096.16	562,110,096.16
51101	Өмч: - төрийн	562,110,096.16	562,110,096.16
512	Хуримтлагдсан үр дүн	-38,387,301.62	285,538,598.96
51210	Өмнөх үеийн үр дүн	-52,523,502.55	-36,661,956.68
51220	Тайлант үеийн үр дүн	14,136,200.93	322,200,555.64

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	284,445,084.79	282,719,739.85
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	808,167,879.33	1,130,368,434.97

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
УЦУОШТ_{өв}

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	920,013,628.98	1,355,696,493.12
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	97,617,828.98	419,120,693.12
120	Нийтлэг татварын бус орлого	97,617,828.98	419,120,693.12
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	97,617,828.98	419,120,693.12
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	100,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	96,962,564.16	419,020,693.12
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	822,395,800.00	936,575,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	817,260,800.00	932,597,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	817,260,800.00	932,597,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,135,000.00	3,978,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,135,000.00	3,978,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	902,493,992.69	1,033,495,937.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	902,493,992.69	1,033,495,937.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	901,329,492.14	1,032,658,034.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	687,611,413.95	784,520,719.63
210101	Үндсэн цалин	560,905,413.95	623,267,119.63
210102	Нэмэгдэл	98,805,800.00	133,353,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,900,200.00	27,900,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,968,571.82	97,700,425.76
210201	Тэтгэврийн даатгал	55,184,988.68	66,657,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,072,406.00	7,842,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,481,525.00	6,273,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,513,462.39	1,568,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,716,189.75	15,359,225.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,780,411.00	19,774,162.60
210301	Гэрэл, цахилгаан	4,178,212.00	3,123,162.60

УЦУОШТ-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

210302	Түлш, халаалт	16,602,199.00	16,651,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	45,128,052.77	39,717,041.01
210401	Бичиг хэрэг	3,742,026.00	4,086,813.33
210402	Тээвэр, шатахуун	5,159,430.00	7,235,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,156,014.78	4,861,866.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	123,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	33,820,581.99	23,409,461.18
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,831,810.00	12,898,681.69
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	11,000,631.69
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	774,300.00	355,550.00
210604	Урсгал засвар	8,057,510.00	1,542,500.00
2107	Томилолт, зочны зардал	4,621,500.00	6,844,700.00
210702	Дотоод албан томилолт	4,621,500.00	6,844,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,487,301.72	7,330,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,929,421.72	6,334,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	118,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	138,900.00	138,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	127,000.00	151,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	30,000.00	55,000.00
210807	Газрын төлбөр	261,980.00	533,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,900,430.88	63,871,403.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	205,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	168,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	44,900,430.88	63,498,403.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,164,500.55	837,903.43
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	402,489.27	837,903.43
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	402,489.27	837,903.43
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>17,519,636.29</u>	<u>322,200,555.64</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>14,136,200.93</u>	<u>322,200,555.64</u>

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	822,495,800.00	937,869,860.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	100,000.00	100,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	100,000.00	100,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	100,000.00	100,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	100,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	822,395,800.00	937,769,860.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	817,260,800.00	932,597,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	817,260,800.00	932,597,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,135,000.00	3,978,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,135,000.00	3,978,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	00.00	1,194,060.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	1,194,060.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	821,445,810.00	935,553,960.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	821,445,810.00	935,553,960.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	820,281,309.45	933,521,996.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	687,611,413.95	784,195,945.39
210101	Үндсэн цалин	560,905,413.95	622,942,345.39
210102	Нэмэгдэл	98,805,800.00	133,353,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,900,200.00	27,900,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,413,307.00	98,025,200.00
210201	Тэтгэврийн даатгал	55,003,307.00	66,657,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,852,500.00	7,842,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,481,900.00	6,273,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,370,500.00	1,568,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,705,100.00	15,684,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,443,212.00	18,396,162.60
210301	Гэрэл, цахилгаан	4,178,212.00	3,123,162.60
210302	Түлш, халаалт	15,265,000.00	15,273,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,706,564.78	12,668,788.58
210401	Бичиг хэрэг	670,900.00	670,900.00
210402	Тээвэр, шатахуун	6,100,250.00	6,283,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,156,014.78	5,185,488.58
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	225,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	529,400.00	302,900.00
2105	Норматив зардал	552,600.00	552,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	552,600.00	552,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,399,900.00	2,130,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	673,200.00	464,700.00

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	381,700.00	392,000.00
210604	Урсгал засвар	5,345,000.00	1,274,100.00
2107	Томилолт, зочны зардал	4,621,500.00	6,844,700.00
210702	Дотоод албан томилолт	4,621,500.00	6,844,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,024,201.72	9,731,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,438,321.72	6,989,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	118,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	138,900.00	138,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	127,000.00	151,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	30,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,028,000.00	1,745,100.00
210807	Газрын төлбөр	261,980.00	533,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	508,610.00	976,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	508,610.00	976,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,164,500.55	2,031,963.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	1,194,060.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	1,194,060.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	402,489.27	837,903.43
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	402,489.27	837,903.43
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,049,990.00</u>	<u>2,315,900.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>1,049,990.00</u>	<u>2,315,900.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>1,049,990.00</u>	<u>2,315,900.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	1,049,990.00	2,315,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,049,990.00	2,315,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-1,049,990.00</u>	<u>-2,315,900.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
УЦУОШТөв СТ-4А

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	562,110,096.16	284,445,084.79	-38,387,301.62	808,167,879.33
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	562,110,096.16	284,445,084.79	-38,387,301.62	808,167,879.33
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,725,344.94	1,725,344.94
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	562,110,096.16	284,445,084.79	-36,661,956.68	809,893,224.27
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-1,725,344.94	00.00	-1,725,344.94
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	322,200,555.64	322,200,555.64
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	562,110,096.16	282,719,739.85	285,538,598.96	1,130,368,434.97

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	845,225,500.00	839,541,383.00	932,697,800.00	932,697,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	845,225,500.00	839,541,383.00	932,697,800.00	932,697,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	845,225,500.00	839,541,383.00	932,697,800.00	931,859,896.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	713,211,100.00	713,211,100.00	784,202,400.00	784,195,945.39
210101	Үндсэн цалин	685,029,100.00	687,377,600.00	622,948,500.00	622,942,345.39
210102	Нэмэгдэл	00.00	00.00	133,353,700.00	133,353,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	28,182,000.00	25,833,500.00	27,900,200.00	27,900,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,453,400.00	78,405,625.00	98,025,200.00	98,025,200.00
210201	Тэтгэврийн даатгал	49,924,800.00	49,894,488.49	66,657,200.00	66,657,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,705,700.00	5,702,227.24	7,842,000.00	7,842,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,132,200.00	7,127,784.49	6,273,600.00	6,273,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,426,500.00	1,425,557.13	1,568,400.00	1,568,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,264,200.00	14,255,567.65	15,684,000.00	15,684,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,725,000.00	18,224,236.00	19,227,600.00	18,396,162.60
210301	Гэрэл, цахилгаан	3,280,000.00	3,911,996.00	3,954,600.00	3,123,162.60
210302	Түлш, халаалт	17,445,000.00	14,312,240.00	15,273,000.00	15,273,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,045,100.00	5,213,896.00	10,226,800.00	10,226,788.58
210401	Бичиг хэрэг	617,400.00	684,835.00	670,900.00	670,900.00
210402	Тээвэр, шатахуун	4,166,900.00	2,586,200.00	5,191,600.00	5,191,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,833,600.00	1,717,548.24	3,835,500.00	3,835,488.58

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	00.00	225,900.00	225,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	360,000.00	225,312.76	302,900.00	302,900.00
2105	Норматив зардал	558,200.00	558,200.00	552,600.00	552,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	558,200.00	558,200.00	552,600.00	552,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,134,400.00	3,134,400.00	4,446,700.00	4,446,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	800,000.00	816,700.00	673,200.00	673,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	440,000.00	397,800.00	392,000.00	392,000.00
210604	Урсгал засвар	1,894,400.00	1,919,900.00	3,381,500.00	3,381,500.00
2107	Томилолт, зочны зардал	6,581,000.00	5,640,880.00	5,308,700.00	5,308,700.00
210702	Дотоод албан томилолт	6,581,000.00	5,640,880.00	5,308,700.00	5,308,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,517,300.00	14,153,046.00	9,731,300.00	9,731,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,633,850.00	13,572,960.00	6,989,400.00	6,989,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	120,000.00	118,800.00	118,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	104,050.00	104,050.00	138,900.00	138,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	143,000.00	136,400.00	151,000.00	151,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	30,000.00	16,500.00	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	00.00	1,745,100.00	1,745,100.00
210807	Газрын төлбөр	401,500.00	203,136.00	533,100.00	533,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1000000.00	1000000.00	976500.00	976500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	1,000,000.00	976,500.00	976,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	00.00	00.00	932,697,800.00	932,697,800.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00	932,597,800.00	932,597,800.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	00.00	00.00	932,597,800.00	932,597,800.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих				

120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	00.00	100,000.00	100,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00	100,000.00	100,000.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	00.00	00.00	82.00	82.00
620001	Удирдах ажилтан	00.00	00.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	00.00	00.00	76.00	77.00
620003	Үйлчлэх ажилтан	00.00	00.00	05.00	04.00

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1.Нийт зарлаг ба цэвэр зээлийн дүн	3978000	3978000
Бараа үйлчилгээний зардал	3978000	3978000
Хангамж бараа материалын зардал	2442000	2442000
Тээвэр шатахуун	1092000	1092000
Шуудан холбоо интернэтийн төлбөр	1350000	1350000
Томилолт зочны зардал	1536000	1536000
Дотоод томилолтын зардал	1536000	1536000

